САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН
2026 ОНЫ 10 ДУГААР САРЫН АЖЛЫН ТАЙЛАН

2026 оны 10 дугаар сарын 29-ний өдөр Орхон аймаг

1. Үндсэн үйл ажиллагаа:

Аймгийн Засаг даргын 2025 оны А/17 захирамжаар 12 орон тоотой байгууллагын стратеги төлөвлөгөөний **5 зорилгын** хүрээнд 2026 оны Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг **7 зорилтын** хүрээнд **44 арга хэмжээг** төлөвлөн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

1.1. Байгууллагын “Эрсдэлийн үнэлгээний журам”-ын дагуу 2026 оны Дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан **55** байгууллагаас 2026 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн байдлаар **47** байгууллагын хяналт шалгалт бүрэн дууссан, **4** байгууллагын хяналт шалгалт 10-80%-тай үргэлжилж байна.

Дотоод аудит, хяналт шалгалтын төрөл:

Он	ДА, СХШ-ын /төлөвлөгөөт +төлөвлөгөөт бус тоо/	2026.10.29-ний өдрөөр батлагдсан удирдамжийн тоо	Төлөвлөгөөт	Төлөвлөгөөт бус	Дотоод аудит	Санхүүгийн хяналт шалгалт
2026	**55+4**	**55**	**51**	**4**	**28**	**27**





2026 оны 10 дугаар сарын 29-ний өдрөөр төлөвлөгөөт хяналт шалгалтын биелэлт шалгалт бүрэн дууссан 47 буюу **85%-тай** байна. **Тайлбар:** Хяналт, шалгалтын төлөвлөгөөний биелэлтийг өссөн дүнгээр мэдээллэж байгаа болно.

-Шалгалт бүрэн дууссан байгууллагууд:

1. Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ
2. Их шүтээн ОНӨААТҮГ
3. Үйлс бадрах ӨЭМТөв
4. Баян-Өндөр сумын Хоршоо хөгжүүлэх сан

5. 20-р цэцэрлэг
6. 5-р цэцэрлэг
7. 2-р цэцэрлэг
8. 16-р цэцэрлэг
9. Жаргалант сумын хоршоо хөгжүүлэх сан
10. 11-р цэцэрлэг
11. 24-р цэцэрлэг
12. 19-р цэцэрлэг
13. 4-р цэцэрлэг
14. 3-р цэцэрлэг
15. 21-р цэцэрлэг
16. Хотын захирагчийн алба **(төлөвлөгөөт бус)**
17. 10-р цэцэрлэг
18. 4-р сургууль
19. 8-р сургууль
20. “Жаргалант ус дулаан түгээх станц” ОНӨХК **(төлөвлөгөөт бус)**
21. Оюу цэцэрлэг
22. Одод цэцэрлэг
23. Баян-Өндөр сумын ОНХСан
24. Татварын газар
25. 20-р сургууль
26. Гаалийн газар
27. Худалдан авах ажиллагааны газар
28. Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламжийн газар
29. 1-р сургууль
30. Бялзуухай цэцэрлэг
31. 7-р цэцэрлэг
32. 17-р цэцэрлэг **(төлөвлөгөөт бус)**
33. Хот тохижуулах газар
34. Аймгийн Орон нутгийн хөгжлийн сан
35. Эрдэнэт сан
36. Жаргалант сумын Болзошгүй аваарын зардал
37. Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар
38. Теле камер хяналтын дэд төв
39. Зэст багийн амралт чөлөөт цагийн талбайн тохижилтын ажил **(төлөвлөгөөт бус)**
40. Биеийн тамир спортын газар
41. 2-р сургууль
42. 13-р сургууль
43. Хотын захирагчийн алба
44. Орхон аймгийн музей
45. Архивын хэлтэс
46. 14-р сургууль
47. Жаргалант сумын ЗДТГ
48. Баян-Өндөр сумын ЗДТГ
49. Баян-Өндөр сумын Болзошгүй аваарын зардал
50. 1-р цэцэрлэг
51. 16-р сургууль

Дээрх байгууллагуудын гүйцэтгэсэн дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, дүгнэлтийг байгууллагуудын удирдлага, нягтлан бодогч нарт танилцуулж, тогтоосон акт,

албан шаардлага, ажил сайжруулах зөвлөмжийн биелэлтийг тогтоосон хугацаанд хангуулан ажиллаж байна.

-Шалгалт бүрэн дуусаагүй байгууллагууд:

1. Жаргалант сумын ОНХСан
2. Эрдэнэт-ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК
3. Уран эгшиг сургууль
4. Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургууль

Дээрх байгууллагуудын 2025 оны төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн хүрээнд санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг гүйцэтгэж байна.

1.2. Аймгийн Засаг даргын төсвийн багцад хамаарах 85 байгууллагын 2026 оны 3 дүгээр улирлын "Шилэн дансны тухай хууль"-ийн хэрэгжилтэд дотоод аудитыг гүйцэтгэж байна. Гүйцэтгэлийн явц 60%-ийн биелэлттэй байна.

1.3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”, “Ногоон эрдэнэт хөтөлбөр”-ийн хүрээнд аймгийн Засаг даргын 2026.09.28-ны өдрийн А/790 захирамжийн биелэлтийг хангахаар 2026.10.10-ны өдөр намрын бүх нийтийн мод тарилтын арга хэмжээнд албан хаагчид идэвхитэй оролцсон.




1.4. “Нэгдсэн менежментийн тогтолцоо”-ны хэрэгжилтэд стандарт баталгаажуулалтын “МонСертф” ХХК-ийн ОУ-ын тэргүүлэх аудитор, Баталгаажуулалтын шинжээч П.Цэцэгмаа, ОУ-ын тэргүүлэх аудитор, зөвлөх, сургагч багш Д.Ариунтуул нар 2026 оны 10 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд ажиллаж, Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 Олон улсын стандартын магадлах-2 аудит, Авлигын эсрэг менежментийн тогтолцооны ISO 37001:2025 Олон улсын стандартын давтан аудит, Эрсдэлийн менежментийн тогтолцооны ISO 31000:2018 Олон улсын стандартын магадлах аудитыг тус тус хийж гүйцэтгэлээ.

Чанарын менежментийн тогтолцооны ISO 9001:2015 Олон улсын стандартын магадлах-2 аудит, Авлигын эсрэг менежментийн тогтолцооны ISO 37001:2025 Олон улсын стандартын давтан аудит, Эрсдэлийн менежментийн тогтолцооны ISO 31000:2018 Олон улсын стандартын магадлах аудитаар нийт 111 шалгуур үзүүлэлтээр дүгнүүлж, аудитад амжилттай хамрагдлаа.







2. СУРГАЛТ, ЗӨВЛӨГӨӨН:

2.1. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан "7:4:10" вебинар цахим-вебинар мэдээллийн цагийн хөтөлбөрөөр зохион байгуулагдсан **4 удаагийн** сургалтад давхардсан тоогоор **25 албан хаагч** хамрагдлаа.

- 2026.10.08-ны өдөр “Төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлтийн эрх зүйн зохицуулалт хэрэглээ” сэдэвт сургалтад 10 албан хаагч
- 2026.10.09-ны өдөр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас цахимаар зохион байгуулсан “Өргөдөл гомдлын систем”-ийн ашиглалтын талаарх сургалтад Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн, Архив, бичиг хэргийн эрхлэгч нар




- 2026.10.15-ны Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс “Стресс менежмент, Ажлаас халшрах хам шинжийн тухай” сэдэвт сургалтад 2 албан хаагч
- 2026.10.29-ний өдөр Нийгмийн даатгалын ерөнхий газраас “Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулга, хэрэгжилт” сэдэвт сургалтад 11 албан хаагч

2.2. Дотооддоо зохион байгуулсан төлөвлөгөөт сургалт:

- Залуучуудын сарын аяны хүрээнд 2026.10.20-ны өдөр “Насан туршийн суралцахуйн төв”-тэй хамтран **“Эмэгтэйчүүдийн дижитал аюулгүй байдал”** сэдэвт сургалтыг албан хаагчдад зохион байгууллаа.





2.3. Дээд газруудаас зохион байгуулагдсан **3 удаагийн** сургалтад давхардсан тоогоор **17 албан хаагч** хамрагдсан.

- 2026.10.21-ний өдөр Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Байгууллагын соёл ба ёс зүй” сэдэвт цахим сургалтад ёс зүйн дэд хорооны 3 гишүүн хамрагдлаа.





- 2026.10.28-ны өдөр Монгол Улсын Ёс зүйн хорооноос зохион байгуулсан “Ёс зүй, сахилга хариуцлага”-ын үнэлгээний шалгуур үзүүлэлт, үнэлэх арга зүй сэдэвт сургалтад байгууллагын Ёс зүйн дэд хорооны 3 гишүүн, Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн нар
- 2026.10.28-ны өдөр Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас зохион байгуулагдсан “Нэгдсэн хяналтын удирдлагын систем (dashboard.gov.mn)-ийн ашиглалт, хэрэглээний тухай”, “Өргөдөл, гомдлын нэгдсэн мэдээллийн сангийн систем (urgudul.gov.mn) системийн хөгжүүлэлт, ашиглалтын тухай” сэдэвт цахим сургалтад 10 албан хаагч

3.Үүрэг даалгавар: 10 дугаар сард Засаг даргын өргөтгөсөн шуурхайгаас **2 үүрэг даалгавар** ирснийг хэрэгжилтийг ханган ажилласан. Үүрэг даалгаврын биелэлтийг тогтоосон хугацаанд и-оффис системд хааж, биелэлтийн тайланг аймгийн ХШҮХ-т тухай бүр хүргүүлсэн.

ОНЦЛОХ АЖИЛ, МАНЛАЙЛАЛ:

- 2026.10.07-ны өдөр Жаргалант сумын ЗДТГ-тай хамтран "Орон нутгийн засаглалын тогтолцоо ба үр нөлөөтэй удирдлага" (засаглал-эрсдэлийн удирдлага-дотоод хяналт) сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтад Жаргалант сумын ИТХ-ын төлөөлөгч, ажлын алба, Засаг дарга, ЗДТГ, төсвийн байгууллагуудын удирдлага, санхүү, Эрсдэл, Дотоод хяналт хариуцсан 30 гаруй албан хаагчид хамрагдлаа.







- 2026.10.14-ний өдөр Орхон аймгийн "Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс" болон "Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын Орхон салбар" хамтран төсөвт байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, байгууллагын үйл ажиллагааны үр нөлөө, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор сургалт зохион байгуулсан. Тус сургалтад Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын Дотоод аудитор-санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Б.Баасансүрэн **“Төрийн байгууллагын үр нөлөөтэй удирдлага: Засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналт”** сэдвээр илтгэл танилцуулж, сайн засаглалыг бэхжүүлэх, эрсдэлийг үр дүнтэй удирдах, дотоод хяналтын тогтолцоог боловсронгуй болгох чиглэлээр мэдээлэл өглөө.





- 2026.10.20-ны өдөр Баян-Өндөр сумын ЗДТГ-тай хамтран "Орон нутгийн засаглалын тогтолцоо ба үр нөлөөтэй удирдлага" (засаглал-эрсдэлийн удирдлага-дотоод хяналт) сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтад Баян-Өндөр сумын ИТХ-ын ажлын алба, Засаг даргын ЗДТГ-ын албан хаагчид хамрагдлаа.





2026.10.14-ны өдөр Олон улсын “Дэлхийн стандартын өдөр”-ийг тохиолдуулан зохион байгуулсан “Стандарт ба Чанар – 2026” арга хэмжээг Монголын Чанарын Менежментийн Холбоо, “МонСертф” ХХК, Олон Улсын Стандартын Академи хамтран зохион байгуулсан арга хэмжээнд ISO олон улсын стандарт нэвтрүүлсэн төрийн болон хувийн хэвшлийн 100 гаруй аж ахуйн нэгж, байгууллагуудын 500 гаруй удирдлага, ажилтан албан хаагч, стандартын салбарын мэргэжилтэн, зочид төлөөлөгч оролцсон.

Олон улсын стандартыг нэвтрүүлэн бодит үр дүнд хүрч, салбар бүрт манлайлан ажилласан 10 салбарын шилдгүүдээ тодрууллаа. Манай байгууллага нь төрийн болон төрийн бус байгууллагын салбарт **"ЧАНАРЫН МАНЛАЙЛЛЫН ШАГНАЛ-2026"** цом, өргөмжлөлөөр шагнагдлаа.





11 ДҮГЭЭР САРД ЗОХИОН БАЙГУУЛАГДАХ АЖЛУУД:

- Төлөвлөгөөт хяналт шалгалтууд хуваарийн дагуу явагдана.
- Цаг үеийн болон төлөвлөгөөт бус байгууллагад холбогдох арга хэмжээнд тогтмол идэвхтэй оролцоно.

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР